



БАГАНУУР ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН
ХЭЛТЭС



МАЛ ТООЛЛОГО-2011

ОРШИЛ

Монгол улсын үндсэн хуулинд мал сүргийг үндэсний баялаг мөн хэмээн томъёолж, энэ ч утгаараа мал тооллогын ажлыг улсын хэмжээнд жил бүр зохион байгуулж, үр дүнг нь макро түвшинд хийгддэг тооцоо, судалгаанд ашиглаж, салбарын талаар удирдлагын шийдвэр гаргах мэдээллийн гол эх үүсвэр болгон ашиглаж байна.

Статистикийн тухай Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоолын дагуу аймаг, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсүүд жил бүрийн 12 сарын 7-17 өдрүүдэд “Мал, тэжээвэр амьтдын тооллого”-ыг зохион байгуулж явуулдаг билээ.

Үүний дагуу дүүрэгт 2011 оны тооллогыг нийслэлийн Засаг даргын 861 тоот захирамжийг үндэслэн дүүргийн Засаг даргын 2011.11.22-ны өдрийн А/421 тоот захирамжаар энэ оны мал, тэжээвэр амьтдын тооллого явуулах ажлын хэсэг, тэдний ажиллах удирдамжийг батлуулан тооллогын хугацаанд амжилттай зохион байгуулж явууллаа.

Мал тооллогын дүнг нэгтгэн дүгнэсэн энэхүү судалгаа нь дүүргийн мал аж ахуйн салбарын өнөөгийн байдалд дүгнэлт хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулах, төлөвлөхөд суурь мэдээлэл болно гэдэгт итгэлтэй байна.

ТОВЧ ТАЙЛБАР, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

Малтай өрх: Малчин өрхөөс гадна малыг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй өсгөн үржүүлдэг өрхийг хэлнэ.

Малчин өрх: Жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болгож байгаа өрхийг хэлнэ.

Малчид: Жилийн 4 улирлын туршид мал аж ахуйг эрхэлж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа 16 ба түүнээс дээш насны хүмүүсийг хэлнэ.

Таван хошуу малыг бодод шилжүүлэх коэффициент:

- 1 тэмээ – 1.5 бод
- 1 адуу – 1 бод
- 1 үхэр – 1 бод
- 6 хонь – 1 бод
- 8 ямаа – 1 бод

Таван хошуу малыг хонин толгойд шилжүүлэх коэффициент:

- 1 тэмээ - 5 хонь
- 1 адуу - 7 хонь
- 1 үхэр - 6 хонь
- 1 хонь - 1 хонь
- 1 ямаа - 0.9 хонь

Нас гүйцсэн мал: Малын төрөл бүр дээр сүүлчийн 2 насны малыг хэлнэ.

- Тэмээ - 4 настай, 5 ба түүнээс дээш настай
- Адуу - 3 настай, 4 ба түүнээс дээш настай
- Үхэр - 2 настай, 3 ба түүнээс дээш настай
- Бог мал /хонь, ямаа/-тухайн жилийн төл малаас бусад насны мал

Өсвөр насны мал:

- Тэмээ - Өнгөрсөн жилийн төл, 2, 3 настай
- Адуу - Өнгөрсөн жилийн төл, 2 настай
- Үхэр - Өнгөрсөн жилийн төл

Төл мал: Тухайн жилийн төлийг хэлнэ.

Бэлэн хээлтэгч: Малын төрөл бүр дээр сүүлийн 2 насны эм малыг хэлнэ.

Малын тоо, толгойн өсөлт: Оны эцсийн малаас оны эхний малыг хасч гаргана. Харьцангуй үзүүлэлтүүдийг гаргахдаа оны эцсийн малын тоог эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ. Малын өсөлтийн орлого тал нь төл бойжилт болон худалдаж авсан, шилжиж ирсэн мал, зарлага тал нь худалдсан, шилжүүлсэн мал болон хэрэглээний зарлага, том малын зүй бусын хорогдол болно.

Төллөлтийн хувь: Төллөсөн хээлтэгчийн тоог оны эхний хээлтэгчийн тоонд харьцуулан, 100-гаар үржүүлнэ.

Бойжилтын хувь: Бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ.

100 эхээс бойжуулсан төл: Бойжуулсан төлийн тоог оны эхний хээлтэгч малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ.

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо: Хээлтэгч малын тоог хээлтүүлэгч малын тоонд харьцуулан гаргана.

1 хээлтүүлэгчид ногдох хээлтэгчийн тооны норм нь:

- 1 Буур – 20 ингэ
- 1 Азарга - 10 гүү
- 1 Бух - 25 үнээ
- 1 Хуц, ухна – 50-60 эм хонь, эм ямаа

Малын зүй бусын хорогдолд өвчний (халдвартай, халдваргүй) хорогдол, гэнэтийн аюулын (цас зуд, үер ус, гал түмэр, аянга цахилгаан зэрэг) хорогдол, бусад шалтгааны (малын хариулга, арчилгаа маллагаатай холбогдон гарсан) хорогдлыг оруулна.

Том малын зүй бус хорогдлын оны эхний малд эзлэх хувь: Зүй бусаар хорогдсон малын тоог, оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ.

Малын хэрэглээний зарлага: Оны эхний малын тоон дээр бойжуулсан төлийг нэмж, том малын зүй бус хорогдол, оны эцсийн малын тоог хасч гаргана.

Малын хашааны хангамж: Хашааны хангамжийг гаргахдаа хашааны багтаамжийг малын тоонд харьцуулан гаргана. Бод малын хашааны хангамжийг гаргахдаа бодын хашааны багтаамжийг үхрийн тоонд, харин бог малынхыг богийн хашааны багтаамжийг бог малын /хонь, ямаа/ тоонд харьцуулна.

Тэжээл хангамж: Тэжээлийн хангамжийг гаргахдаа тэжээлийн нэгжид шилжүүлсэн тэжээлийн хэмжээг хонин толгойд шилжүүлсэн малын тоонд харьцуулан гаргана. Малын хангамж, бэлчээрийн даацыг гаргахдаа малыг хонин толгойд шилжүүлэн тооцно.

Тэжээлийн нэгжид шилжүүлэх коэффициент: Бэлтгэсэн тэжээл нь илчлэг, чанарын байдлаараа харилцан адилгүй байдаг учраас нэг тэжээлийн нэгжид шилжүүлж тэжээлийн хангамжийг гаргана. Үүний тулд доорхи

- | | | |
|-------------------------|------|---|
| • Хадлан өвс | 0.45 | |
| • Таримал тэжээл | 0.35 | |
| • Даршны ургамал | 0.25 | |
| • Гар тэжээл, хужир шүү | 1.0 | |
| • Үр тарианы хаягдал | 0.9 | |
| • Лай | 0.4 | |
| • Сүрэл | 0.25 | гэсэн итгэлцүүрүүдийг ашиглан тэжээлийн нэгжид шилжүүлнэ. |

Малын тэжээлийн ангилал: Малын тэжээлийг ургамлын гаралтай, амьтны гаралтай, эрдэс тэжээлийн гаралтай гэж ангилна.

Ургамлын гаралтай тэжээлд өвс, сүрэл, үр тариа, буурцгийн төрлийн ургамал орох бөгөөд бүдүүн, хүчит, шүүст тэжээл гэж ангилна. Үүнд:


- Бүдүүн тэжээл - өвс, сүрэл, нэг наст ба олон наст өвс
- Хүчит тэжээл - үр тариа, үр тарианы хаягдал, вандуй, буурцаг
- Шүүст тэжээл – Бүх төрлийн дарш, төмс ногооны хаягдал

Амьтны гаралтай тэжээлд үйлдвэрийн яс, цусны гурил зэрэг орно. Эрдэс тэжээлд давс, хужир шүү орно.

МАЛТАЙ ӨРХ, МАЛЧДЫН ТОО, ТЭДНИЙ СОЁЛ АХУЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД:

Малтай өрх, малчдын тоо. Дүүрэгт 2011 оны тооллогоор хувийн малтай 473 өрх, үүний дотор 240 малчин өрх мал аж ахуй эрхэлж байна. Үүнийг өнгөрсөн онтой харьцуулахад:

	2008 он	2009 он	2010 он	2011 он	
Малтай өрх	1-р хороо	158	127	132	98
	2-р хороо	70	73	61	63
	3-р хороо	177	147	144	124
	4-р хороо	289	208	162	110
	5-р хороо	-	-	-	78
Дүүргийн дүн	694	555	499	473	
Малчин өрх	1-р хороо	80	72	65	55
	2-р хороо	36	35	31	33
	3-р хороо	91	121	75	68
	4-р хороо	178	175	111	73
	5-р хороо	-	-	-	11
Дүүргийн дүн	385	403	282	250	



2011 оны байдлаар мал аж ахуйн үйлдвэрлэлд 250 өрхийн 850 ам бүл ажилласан байна. Түүний 471 нь мал аж ахуйг эрхэлж, малын ашиг шимийг амьжиргааны эх үүсвэрээ болгон амьдарч байгаа малчид байна. Малчдыг насны бүлгээр авч үзвэл 43.7 хувь нь 16-34 насны, 47.3 хувь нь 35-аас тэтгэвэрт гарах насны, 9.0 хувь нь тэтгэврийн насны хүмүүс байна.

Шигтгээ: Нийт малчдын 219 нь буюу 46.5 хувь нь эмэгтэй малчид байна.

Малтай болон малчин өрх, малчдын тоо

	2008	2009	2010	2011
Малтай өрх	694	555	499	473
Түүний ам бүл	2432	1636	1672	1580
Малчин өрх	385	403	282	240
Түүний ам бүл	1349	1004	976	850
Малчдын тоо	722	847	532	471
16-34 насны	250	370	140	150
35-аас тэтгэвэрт гарах насны	380	401	260	204
Тэтгэврийн насны	92	76	132	117
Нийт малчдаас эмэгтэй	290	302	233	219
Насны бүтэц %	100.0	100.0	100.0	100.0
16-34 насны	34.6	43.7	26.0	31.8
35-аас тэтгэвэрт гарах насны	52.6	47.3	49.0	43.3
Тэтгэврийн насны	12.7	9.0	25.0	24.9

Мал÷дын тоо /насны бүлгээр/




Дүүргийн 2011 оны малтай өрхийн тоог өнгөрсөн онтой харьцуулахад 26-аар буюу 5.2 хувиар, малчин өрх 42-оор буюу 14.9 хувиар, малчид 471 болж 61 малчинаар буюу 11.5 хувиар тус тус буурсан байна.

Малчдын соёл, ахуйн үзүүлэлт.

2011 оны тооллогоор нийт малчин өрхийн

- 240 өрх буюу 100.0% нь цахилгааны эх үүсгүүртэй
- 206 өрх буюу 85.8% нь телевизортэй
- 104 өрх буюу 43.3% нь автомашинтай
- 127 өрх буюу 52.9% нь мотоцикльтай
- 202 өрх буюу 84.2% хувь нь малын хашаатай байна.

Мал÷дын соёл ахуйн үзүүлэлтүүд




МАЛЫН ТОО, БҮТЭЦ: 2011 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр дүүргийн малын тоо 92066 толгойд хүрч, өнгөрсөн оныхоос 8673 толгой малаар буюу 10.4 хувиар өссөн.

Малын тоо, төрлөөр

	2008	2009	2010	2011	2011/2010	
					зөрүү	хувь
НИЙТ МАЛЫН ТОО	110372	111226	83393	92066	8673	10.4
Тэмээ	110	121	162	74	-88	-54.3
Адуу	6465	5581	5054	6021	967	19.1
Үхэр	8184	6884	5571	5843	272	4.9
Хонь	52411	56800	43028	46238	3210	7.5
Ямаа	43202	41840	29578	33890	4312	14.6

Энэ жилийн тооллогоор тэмээн сүрэг 88 толгойгоор буюу 54.3 хувиар буурч, адуун сүрэг 967 толгой буюу 19.1 хувиар, үхэр сүрэг 272 толгой буюу 4.9 хувиар, хонин сүрэг 3210 толгой буюу 7.5 хувиар, ямаан сүрэг 4312 толгой буюу 14.6 хувиар тус тус өссөн байна.

Малын тоо /толгой/



Малын орлого, зарлага, төрлөөр

Оны эх	Орлого				Зарлага				Оны эцэс
	Худалдаж авсан, шилжиж ирсэн	Бэлэн тоологдсон төл	Худалдсан шилжүүлсэн	Алдсан	Зах зээлд борлуулсан	Дотоод хэрэгцээнд	Зүй бус хорогдол		
Тэмээ	162	1	7	93	0	3	0	0	74
Адуу	5054	2109	1161	1820	50	112	222	99	6021
Үхэр	5571	1351	1717	2064	4	290	318	120	5843
Хонь	43028	7565	15970	13340	57	3452	3072	404	46238
Ямаа	29578	7481	10780	10461	43	1243	1757	445	33890
Дүн	83393	18507	29635	27778	154	5100	5369	1068	92066

Дээрх хүснэгтээс харахад энэ жил бэлэн тоологдсон төлөөр 29635 толгой, худалдаж авсан болон шилжиж ирсэн малаар 18507 толгой мал тус тус нэмэгдэж орлого талыг бүрдүүлж байхад харин худалдсан, шилжүүлсэн малын тоо 27778 толгой, аж ахуйн дотоод хэрэгцээнд 5369 толгой мал хэрэглэж зарлага талын үзүүлэлтийг тодорхойлж байна. Мөн өнгөрсөн жилд 1068 толгой том мал зүй бусаар хорогдсон байна.

Мөн малын тооны бууралтанд өөр үзүүлэлтүүд хэрхэн нөлөөлснийг доорх хүснэгтэнд харуулья.

Малын тооны өсөлт, бууралтанд нөлөөлсөн үзүүлэлтүүд

	2008	2009	2010	2010	2011/2010	
					зөрүү	хувь
Бэлэн тоологдсон төл	35460	35951	17389	29635	12246	70.4
Том малын зүй бусын хорогдол	361	953	16363	1068	-15295	-93.5
Хээлтэгч малын тоо	35594	51835	51338	43898	-7440	-14.5
Хээл хаясан хээлтэгч	479	1328	5963	762	-5201	-87.2
Сувайрсан хээлтэгч	713	2309	3849	2007	-1842	-47.9

Дээрх хүснэгтээс харахад энэ жил том малын зүй бус хорогдол, хээл хаясан хээлтэгч болон сувайрсан хээлтэгч өнгөрсөн жилүүдээс буурсан нь малын өсөлтөнд эерэгээр нөлөөлсөн байна.

Малын сүргийн бүтэц: 2011 оны байдлаар нийт мал сүргийн 87.0 хувийг бог мал, 13.9 хувийг бод мал эзэлж байна. Нийт сүргийн бүтцэд таван төрлийн малын эзлэх хувийн жинг төрөл тус бүрээр доорх хүснэгтэнд гарган харуулвал:


	2008	2009	2010	2011
НИЙТ МАЛ	100.0	100.0	100.0	100.0
Тэмээ	0.1	0.1	0.2	0.1
Адуу	5.9	5.0	6.1	6.5
Үхэр	7.4	6.2	6.7	6.3
Хонь	47.5	51.1	51.6	50.2
Ямаа	39.1	37.6	35.5	36.8

Үүнээс харахад тэмээ сүргийн хувийн жин харьцангуй хэвийн, адуу, ямаан сүргийн хувийн жин өмнөх оноос өссөн байна. Харин үхэр, хонин сүргийн хувийн жин буурсан байна.

Бог малын бүтцийг харахад нийт бог малын 57.7 хувийг хонин сүрэг, 42.3 хувийг ямаан сүрэг эзэлж байна.

Өмнөх жилүүдэд бог малын жинд ямаан сүргийн эзлэх хувь өндөр байсан бол сүүлийн жилүүдэд ямаан сүргийн эзлэх жин буурах хандлагатай байна. Энэ нь мал сүргийн бүтэц ялангуяа бог малын бүтэц хэвийн болж байгааг харуулна.


Бог малын бүтэц



Малын тоо хороогоор: Малын тоог хороодоор харахад 1, 4-р хороонд 6.9-8.7 хувиар буурч, бусад хороод 4.7-17.2 хувиар өссөн байна. Доорх хүснэгтэнд 2011 оны мал тооллогын дүнг хороодоор ангилан өмнөх онтой харьцуулсан байдлаар харуулж байна.

		2010 он	2011 он	өсөлт, бууралт	
				тоо	хувь
хороогоор	1-р хороо	31110	25160	-2199	-8.7
	2-р хороо	7830	7117	1225	17.2
	3-р хороо	34516	24515	1150	4.7
	4-р хороо	37770	26601	-1845	-6.9
	5-р хороо	-	10342	10342	-
	Дүүргийн дүн	111226	83393	8973	10.4

Амины мал /оноор/



Хувийн /амины/ малын тоо: Мал тооллогоор амины малын тоо 87566 толгойд хүрч нийт малын 95.1 хувийг эзэлж байна. Энэ нь өнгөрсөн оныхоос 8205 толгой малаар буюу 10.3 хувиар өссөн байна. Нийт мал сүргээс тэмээ 100 хувь, адуун сүргийн 98.3 хувь, үхэр сүргийн 95.4 хувь, хонин сүргийн 92.3 хувь, ямаан сүргийн 98.3 хувь нь хувийн аж ахуйд байна.

Хувийн малтай өрх, малын

тоо

Он	Малтай өрх	Бүгд	Үүнээс:					1 өрхийн дундаж мал
			Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	
2008	694	106361	110	6325	8059	49223	42644	153.3
2009	555	106499	121	5461	6782	52902	41233	191.9
2010	499	79361	162	4945	5465	39748	29041	159.0
2011	473	87566	74	5918	5577	42685	33312	185.1

2011 оны байдлаар амины нийт малын 38.0 хувийг ямаа, 48.7 хувийг хонь, 6.8 хувийг адуу, 6.4 хувийг үхэр, 0.1 хувийг тэмээ эзэлж байна. Мөн энэ жил 1 өрх дунджаар 185.1 толгой малтай болсон нь өнгөрсөн жилүүдийнхээс 26.1 орчим толгой малаар буюу 16.4 хувиар өссөн байна.

Шигтгээ: Амины малтай 1 өрхөд дунджаар тэмээ 0.2, адуу 12.5, үхэр 11.8, хонь 90.7, ямаа 70.4 ногдож байна.

Хувийн /амины/ малын бүлэглэлт. Нийт малтай өрхийн 44.6 хувь буюу 211 өрх 100 хүртэлх малтай, 21.6 хувь буюу 102 өрх 101-200 малтай, 25.6 хувь буюу 121 өрх 201-500 малтай байна. Иргэдийн хувийн малын бүлэглэлтийг өнгөрсөн онтой харьцуулан харахад бүх бүлэглэлт дээр буурсан үзүүлэлттэй байна.

Малтай өрхийн малын бүлэглэлт

	Өрхийн тоо		Дүнд эзлэх хувь		Малын тоо	
	2010	2011	2010	2011	2010	2011
0-100 малтай	255	211	51.1	44.6	9025	7161
101-200 малтай	107	102	21.4	21.6	15746	14861
201-500 малтай	109	121	21.8	25.6	33359	37104
501-999 малтай	22	32	4.4	6.8	13686	19901
1000-1499 малтай	5	6	1.0	1.3	5797	6919
1500-2000 малтай	1	1	0.2	0.2	1748	1620
Бүгд	499	473	100.0	100.0	79361	87566

Малын бүлэглэлт тус бүрээр авч үзэхэд 100 хүртэлх толгой малтай 1 өрхөд дунджаар 33.9 толгой мал, 101-200 малтай 1 өрхөд 145.7 толгой мал, 201-500 малтай 1 өрхөд 306.6 толгой мал, 501-999 малтай 1 өрхөд 621.9 толгой мал, 1000 ба түүнээс дээш малтай 1 өрхөд 1153.2 толгой мал тус тус ногдож байна.

Шигтгээ: Малтай нэг өрх дунджаар 3.3 ам бүлтэй байгаа бөгөөд 1 хүнд толгойн тоогоор 61.7 толгой мал ногдож байна.

Мянгат малчид: 2011 оны байдлаар нийт малтай өрхийн 7 өрх буюу 1.5 хувь нь 1000 дээш толгой малтай байна. Үүнээс 1000-1499 малтай өрх 6, 1500-2000 малтай өрх 1 байна. Харин 2000-аас дээш малтай өрх байхгүй байна.

	1000-1500 толгой малтай	1501-2000 толгой малтай
1-р хороо	1	-
2-р хороо	1	-
3-р хороо	1	-
4-р хороо	3	1
5-р хороо	-	-
ДҮН	6	1

Шигтгээ: 2008 онд дүүрэгт анх удаа “**2000 малчин**” төрж байсан ба 2009 онд **2** өрх байсан байна.


Хээлтэгч мал: 2011 оны эцэст 43140 толгой хээлтэгч мал тоологдсон нь өнгөрсөн оныхоос 758 толгойгоор буюу 1.7 хувиар буурсны дотор үнээ 69 толгой, гүү 423 толгойгоор тус тус өсч, харин ингэ 40 толгой, эм ямаа 154 толгой, эм хонь 1056 толгойгоор тус тус буурсан байна.

	2008	2009	2010	2011	2011/2010	
					хувь	зөрүү
Тэмээ	62	46	64	24	-40	-62.5
Адуу	2010	1686	1697	2120	423	24.9
Үхэр	3391	2777	2550	2619	69	2.7
Хонь	25769	27287	23372	22316	-1056	-4.5
Ямаа	20603	19542	16215	16061	-154	-0.9
Бүгд	51835	51338	43898	43140	-758	-1.7

Хээлтэгч мал нийт малын 46.9 хувийг эзэлж байгаа бөгөөд

- тэмээн сүргийн – 32.4 хувь
- адуун сүргийн – 35.2 хувь
- үхэр сүргийн – 44.8 хувь
- хонин сүргийн – 48.3 хувь
- ямаан сүргийн – 47.4 хувийг тус тус эзэлж байна.

Хээлтэгч малын тоо



Бэлэн тоологдсон төл: 2011 оны мал тооллогоор бэлэн тоологдсон төлийн тоо 29635 толгой болж өнгөрсөн оныхоос 12246 толгойгоор буюу 70.4 хувиар өссөн байна.

	2008	2009	2010	2011	2011/2010	
					хувь	зөрүү
Ботго	31	57	13	7	-6	-46.2
Унага	1462	1780	752	1161	409	54.4

Тугал	2664	6667	1369	1717	348	25.4
Хурга	15652	21427	9965	15970	6005	60.3
Ишиг	13787	17969	5290	10780	5490	103.8
Бүгд	33596	47900	17389	29635	12246	70.4

Өнгөрсөн оны тооллогоор 43898 хээлтэгч төллөхөөр тоологдсон бөгөөд:

- хээлтэй малын орлогоор 6169 толгой мал нэмэгдэж
- хээлтэй мал 1344 толгойг зарлагдаж
- хээл хаясан 762 толгой мал
- сувайрсан 2007 толгой мал тус тус хасагдаж нийт 45952 хээлтэгч төллөсөн байна.

Төл бойжилт, төлийн орлого, зарлага, төрлөөр

	Төллөсөн хээлтэгч	Гарсан төл	Хорогдсон төл	Бойжсон төл	Худалдаж авсан ирсэн	Худалдсан явсан
Ботго	59	59	0	59	0	52
Унага	1828	1828	28	1800	72	711
Тугал	2661	2661	24	2637	95	1015
Хурга	24350	24366	256	24110	1023	9163
Ишиг	17054	17107	269	16838	627	6685
Бүгд	45952	46021	577	45444	1817	17626

2011 онд 45952 хээлтэгчээс 46021 төл хүлээн авсан бөгөөд 16 эм хонь, 53 эм ямаа ихэр төл гаргасан байна. Энэ онд төл бойжилт 98.7 хувьтай байна.

Том малын зүй бус хорогдол: 2011 оны тооллогоор 1068 том мал хорогдсон бөгөөд энэ нь оны эхний малын 1.3 хувьтай тэнцэж байгаа нь өнгөрсөн оныхоос 15295 толгойгоор буюу 15.3 дахин буурсан байна. Нийт хорогдсон малын 9.3 хувийг адуун сүрэг, 11.2 хувийг үхэр сүрэг, 37.8 хувийг хонин сүрэг, 41.7 хувийг ямаан сүрэг эзэлж байна.

Том малын зүй бусын хорогдол

	2008	2009	2010	2011	2011/2010	
					зөрүү	Хувь дахин
Тэмээ	0	0	5	0	-5	5
Адуу	64	183	399	99	-300	4.0
Үхэр	70	193	818	120	-698	6.8
Хонь	119	321	8375	404	-7971	20.7
Ямаа	108	256	6766	445	-6321	15.2
Бүгд	361	953	16363	1068	-15295	15.3

2011 онд нийт хорогдсон малын 548 толгой мал буюу 51.3 хувь нь гэнэтийн аюулаар, 520 толгой мал буюу 48.7 хувь нь өвчнөөр хорогдсон байна.

Оны эхний малд зүй бус хорогдлын эзлэх хувь

	2008	2009	2010	2011
Тэмээ	0.0	0.0	3.1	0.0
Адуу	1.2	2.8	7.9	2.0
Үхэр	1.0	2.4	14.7	2.2
Хонь	0.3	0.6	19.5	0.9
Ямаа	0.3	0.6	22.9	1.5
БҮГД	0.4	0.9	19.6	1.3

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо: 2011 онд 833 хээлтүүлэгч мал тоологдож, 2010 оныхоос 80 толгойгоор буюу 10.6 хувиар өссөн байна.

	Хээлтүүлэгч мал			
	2008	2009	2010	2011
Буур	3	3	3	1
Азарга	307	225	253	267
Бух	102	99	66	71
Хуц	331	249	275	305
Ухна	250	197	156	189
Бүгд	993	773	753	833

Хээлтэгч хээлтүүлэгчийн тохироо:

	Үржлийн норм	2008	2009	2010	2011
Ингэ	20	21	15	21	24
Гүү	10	7	7	7	8
Үнээ	25	33	28	39	37
Эм хонь	50	78	110	85	73
Эм ямаа	60	82	99	104	85

Тэмээ, адуун сүрэг дээр сүүлийн жилүүдэд зохистой харьцаа бий болж байгаа нь ажиглагдаж байгаа хэдий ч бог мал болон үхэр сүрэг дээр зохистой харьцаа алдагдсан хэвээр байна.

Үржлийн нормоор бог малын нэг хээлтүүлэгчид 50-60 хээлтэгч ногдох

ёстой атал өнгөрсөн онд дүүрэгт дунджаар 73 эм хонь, 85 эм ямаанд 1 хээлтүүлэгч ногдож байгаа нь харилцан адилгүй харагдаж байна.


МАЛЫН БЭЛЧЭЭР, ТЭЖЭЭЛИЙН ХҮРЭЛЦЭЭ, ХАНГАМЖ:

Бэлчээрийн хүрэлцээ: Манай дүүрэг 62020 га газар нутагтай бөгөөд газрын албаны 2011 оны газрын нэгдмэл сангийн тайлангаар үүний 41699.7 га хөдөө аж ахуйн эдэлбэр газар байна. Үүнээс бэлчээрийн талбай 41068.7 га болсон байна. 2011 онд малын тоо хонин толгойд шилжүүлснээр 154313 толгойд хүрсэн.


Дүүргийн 100 га бэлчээрийн талбайд хонин толгойд шилжүүлснээр 375.7 толгой мал ногдож байна. 100 га бэлчээрийн талбайд ногдох хонин толгойд шилжүүлсэн малын тоо 2010 оныхоос 15051 толгой малаар буюу 10.8 хувиар өссөн байна.

Хадлан бэлтгэл: 2011 онд дүүргийн хэмжээгээр 7000 тонн байгалийн хадлан бэлтгэсэн бөгөөд үүнээс 4500 тонн хадланг иргэд бэлтгэсэн байна.

Малын тоо /хонин толгойд шилжүүлснээр/



Байгалийн хадлан /тонн/



ДҮГНЭЛТ

Багануур дүүргийн 2011 оны мал тооллогын дүнгээр 92066 толгойд хүрч 10.4 хувиар өслөө. Энэ жилийн малын өсөлтөнд том малын зүй бус хорогдлын бууралт, бэлэн тоологдсон төлийн өсөлт, худалдаж авсан болон шилжиж ирсэн малын өсөлт зэрэг нөлөөлсөн байна. Мөн хээл хаясан хээлтэгч болон сувайрсан хээлтэгч өнгөрсөн жилүүдээс буурсан нь бас нөлөөлсөн байна.

Энэ оны өвөлжилтийн байдал өнгөрсөн оноос сайжирч, малчид хадлан тэжээл сайн бэлтгэсэн нь мөн нөлөөлсөн гэж үзэж байна.

Бог малын бүтцэд 2011 оны байдлаар бог малын малын 57.7 хувийг хонин сүрэг, 42.3 хувийг ямаан сүрэг эзэлж байна. Бог малын дотор ямаан сүргийн эзлэх хувийн жин сүүлийн жилүүдэд буурч байгаа нь эерэг хандлагыг бий болгож байна.

Дүүрэгт малын бэлчээрийн газар хомс учир манай малчид зэргэлдээх сумдууд малаа бэлчээрлэн аж төрдөг билээ. Дүүргийн болон зэргэлдээх сумдын удирдлагууд малчдын бэлчээр ашигласны татвар болон бусад асуудлаар харилцан тохиролцсон гэрээ байгуулсан хэдий ч зарим сумдаас бэлчээрийн талаар шахалт үзүүлж элдэв мөнгө төгрөг нэхэх үзэгдэл байна.

Эдгээр шалтгаануудаас болж дүүргийн малчин өрх гэр бүлээ салган шилжиж явах үзэгдэл байсаар байна. Ихэнх малчид эхнэр сургуулийн насны хүүхдээ Багануур дүүргийн харьяанд үлдээн өөрөө малаа даган зэргэлдээх сумдын хаяа бараадан шилжсээр....

Энэ нь жил бүрийн малчин өрхийн болон мал сүргийн бууралтанд тодорхой хэмжээгээр нөлөөлсөн байна.